



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/192

Чойр

“Эрмүүн миж” ХХК-д түгээмэл
тархацтай ашигт малтмалын хайгуулын
тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5, 14 дүгээр зүйлийн 14.7, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.6.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.7 дахь тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шивээговь сумын Дөрвөлж толгойд 182.76 га талбайг хамарсан ХА-42000028 түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг “Эрмүүн миж” ХХК-д 3 жилийн хугацаатай олгож, талбайн байршил солбицолыг хавсралтаар баталсугай.

2. Холбогдох хууль, тогтоомжийн дагуу хайгуулын үйл ажиллагаа явуулан, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, нөхөн сэргээлтийг хугацаанд нь чанартай хийх, хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийг тусгай зөвшөөрөл олгосон өдрөөс эхлэн тооцож жил бүр урьдчилан төлж байхыг “Эрмүүн миж” ХХК-ийн захирал (М.Ганхуяг)-д үүрэг болгосугай.


3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газрын дарга (Б.Ганбаяр), Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (Д.Мөнх-Эрдэнэ), Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Отгончимэг), Шивээговь сумын Засаг дарга (П.Ганчимэг) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.БАТЗАМ



Аймгийн Засаг даргын 2022 оны 06...
дугаар сарын 27 -ны өдрийн А.1192
дугаар захирамжийн хавсралт



Компаний нэр: “Эрмүүн минж” ХХК
Захирал: М.Ганхуяг
Талбайн нэр: Дөрвөлж толгой
Планшет: L-49-79

Байршил.

д/д	Хот, аймаг	Сум, дүүрэг	Талбай, га
1	Говьсүмбэр	Шивээговь	182.76

Солбицлууд.

д/д	Уртраг			Өргөрөг		
	Град	Мин	Сек	Град	Мин	Сек
1	108	21	9.1	45	54	2.02
2	108	21	9.1	45	54	40.68
3	108	22	21.93	45	54	40.68
4	108	22	21.93	45	54	2.02